

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 2 сарын

үйл ажиллагааны тайлан

2021 оны 2 сарын 24-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Хоёрдугаар сард 41 албан бичиг бүртгэгдэж үүнээс хугацаатай 9 албан бичгийг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлэн тусламж хүссэн буюу малжуулах-2 нийт 2 иргэний өргөдлийг бүртгэлд хүлээн авч шийдвэрлээд байна.

Удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж - 20 батлагдаж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

2021 оны 1 сарын байдлаар төрөлт 6, нас баралт 3, гэрлэлт-6, цахим иргэний үнэмлэх шинээр – 2, цахим иргэний үнэмлэх сунгалт - 2, эцэг тогтоолт – 1, орон нутагт өөр аймгаас шилжин ирсэн -1 том хүн, 3 хүүхэд, аймгаас шилжин ирсэн – 1 том хүн, 2 хүүхэд бүртгэгдсэн байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

1 сарын байдлаар орон нутгийн орлого төлөвлөгөөгөөр 4849.0 мянган төгрөг орохоос 6503.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй орлогын төлөвлөгөө 134.1 хувийн биелэлттэй байна.

Орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл:

Орлогын нэр төрөл	2021 онд батлагдсан төсөв	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт орлого	138340.0	4849.0	6503.7
Татварын орлого	53340.0	3599	5534.7
<i>Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар</i>	25000.0	2083	55.3
Хөрөнгө борлуулсны орлого	15000.0	1250	5388.3
<i>үйл ажиллагааны орлого</i>	1200.0	100	36
Бууны албан татвар	1140.0		
Улсын тэмдэгтийн хураамж	2000.0	166	55.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3000.0		
Ан агнуур ашигласны төлбөр	0.0		
Ус ашигласны төлбөр	0.0		
Газрын төлбөр	6000.0		
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.0		
Татварын бус орлого	85000.0	1250	969.0
Хүү торгуулийн орлого	15000	1250	969
Нэр заагдаагүй бусад орлого	70000.0		

төсөвт газрын өөрийн орлого			
Хөрөнгийн орлого	0.0	0	
Хөрөнгө борлуулсны орлого	0.0		
Оны эхний үлдэгдэл	0.0		

2-р сарын байдлаар аймгийн санхүүгийн дэмжлэг 58785,0 мянган төгрөг ирээд байна.

2021 оны орон нутгийн төсвийн байгууллагын орлого зарлагын сарын хуваарийг хийж засаг даргаар батлуулан аймгийн төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

Нягтлан бодогч нар хуулийн хугацаанд нь тайлангаа гаргаж аудитын байгууллагаар шалгуулсан.

Шууд захирагч нарын санхүүгийн тайланг хүлээн авч э-тайланд хуулийн хугацаанд нь шивж оруулсан.

Худалдан авах ажиллагааны талаар:

Ковид19 өвчлөлтэй холбоотойгоор ЕБСургуулийн мэдээлэл зүйн кабинетийн тоног төхөөрөмжийг гүйцэтгэгч компани тендерийн баталгаа гаргаж 20 хувийн санхүүжилтийг он дамжуулж авахаар болсон байсан. Уг дутуу ажлыг тухайн компаниар гүйцэтгүүлж үлдэгдэл санхүүжилтийг олгосон.

Мөн гэржүүлэлтийн тендерийн санхүүжилт гүйлгээ өндөрлөх өдөр орж ирснийг авлага өглөгөөр дамжуулж санхүүгийн тайланд тусгаж тухайн компаний дансанд шилжүүлсэн.

Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтанд 6 төрийн албан хаагчийг хамруулсан.

2021 онд орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн төсөл хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэл

№	Хийгдэх ажил	Төлөвлөгөө	2021 оны гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Гэр цэцэрлэг нэмэгдүүлэх	20,000,000.00		20,000,000.00
2	ЕБС-ийн мэдээлэл зүйн кабинет дутуу	8,978,000.00		8,978,000.00
3	Нийтийн халуун усны барилга	90,000,000.00		90,000,000.00
4	Чийрэгжүүлэлтийн төв	35,000,000.00		35,000,000.00
5	Ухаалаг худгийн төхөөрөмж	9,100,000.00		9,100,000.00

6	Цамхаг гэрэл	9,200,000.00		9,200,000.00
7	Газар чөлөөлөлт	46,165,700.00		46,165,700.00
8	Зураг төсвийн үнэ	3,000,000.00		3,000,000.00
	Дүн	221,443,700.00	-	221,443,700.00

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Байгаль орчин:

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг сумын Засаг даргын 2021 оны 02 сарын 04 ны өдрийн А/20 тоот захирамжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн. Тооллогоор сумын хэмжээний айл өрх, албан газар, аж ахуй нэгжүүд хамрагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 сарын 03-ны өдрийн 211 тоот тогтоолын дагуу ус, дулааны үнийг төлбөрөөс чөлөөлсөнтэй холбогдуулан худаг, уст цэгийн тооцоо судалгааг гарган усны төлбөрийг буцаан олгох ажлыг хийж байна. 2020 оны 12 сарын усны төлбөр болох 1339000 төгрөгийг сумын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэнийг 4 газарт буцаан олгосон. 2 худгийг тооллуурт шилжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Байгаль хамгаалагч:

Монгол улсын засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоол болон Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 242 дугаар тушаалаар батлагдсан “Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр журам”, “Төрөөс хариуцах цэвэр бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам” дагаж мөрдөн. Гэр хорооллын хэрэглэгчдэд үйлчилдэг ус түгээх худагнуудад “Монгол Улсын засгийн газраас таны хэрэглэсэн цэвэр усны төлбөрийг төлж байна” гэсэн бичгийг байрлуулсан.

Байгаль орчин аялал жуулчлалын яамны санхүүжилтаар байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2021 оны төлөвлөгөөнд 3-4 булаг шанд хашиж хамгаалахаар тусгагдсан. Иймд Уулбаян сум 2 булгийн эхийг хашиж хамгаалуулах саналыг хүргүүлсэн.

Агаар бохирдуулын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус ажилд ажлын хэсэг томилогдон ажиллаа. Үүнд:

- Ажлын хэсгийн ахлагч-Засаг даргын орлогч, 2-р багийн Засаг дарга, Цаг уурын ажилтан, Байгаль орчны мэргэжилтэн, Байгаль хамгаалагч нарын бүрэлдэхүүнтэй ажлыг өгсөнд үүрэг чиглэлийн дагуу хугацаанд нь бүрэн гүйцэтгэж хүргүүлсэн.

Газар зохион байгуулалт:

2021.02.22-ноос 2021.02.225-ны хооронд хаягийн мэдээллийн санг хянах хянах, зам, гудамж, талбай, нэгж талбар, үл хөдлөх хаяг, нэр, дугаар олгох засварлах, өөрчлөлт хийх долоо хоногийн хугацаатай сургалтад хамрагдан, тус

хугацаанд 333 нэгж талбар, 71 гудамж, 308 орц, 1046 барилгын хаягийг хянаж, газрын мэдээллийн санд оруулсан.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

2020 оны байдлаар Уулбаян суманд 903 өрхийн 2978 хүн амьдарч байна. Үүнээс малчин өрх 603 мал бүхий өрх 96 байна. 2020 онд 241807 мал тоологдсон байна. Малын тоо толгойг 5-н төрлөөр авч үзвэл тэмээ-767, адуу 17950, үхэр-14079, хонь- 131285, үхэр- 77726 тоологдсон байна. 2019 оны тоотой харьцуулхад тэмээ-94, хонь- 5126-аар буурсан бол адуу-686, үхэр-571, ямаа-300 –аар өссөн байна. ИТХурлаар малын хөлийн татварын хувьд адуу- 1000 төг, үхэр-400 төг, хонь-300 төг , ямаа-600 төгрөгийн татвар авхаар тогтоосон. 1 өрхөөс 150 толгой мал чөлөөлөхөөр адуу-10ш , үхэр-10ш , хонь-100ш , ямаа-30ш гэж тогтоогдсон.

Уулбаян суманд 2021 оны 1 сарын байдлаар Том малын зүй бус хорогдол гараагүй байна.

2021 оны 1 сарын байдлаар нас гүйцсэн ат - 900000 төг, нас гүйцсэн ингэ- 850000 төг, соёолон үрээ - 1000000 төг, соёолон гүү- 800000 төг, хязаалан гуна -1500000 төг, хязаалан гунж-1200000 төг, эр бяруу-650000 төг, эм бяруу -550000 төг, эр хонь-150000 төг, эм хонь-130000 төг, эр төлөг-110000 төг, эм төлөг-100000 төг, эр ямаа-130000 төг, эм ямаа-80000 төг, эр борлон-50000 төг, эм борлон-50000 төгрөгийн үнэтэй байна.

Аймгийн сайн малчнаар Баян багийн малчин С.Цогтсайхан, Ц.Даваасүрэн нар тодров. Сумын сайн малчнаар Баян багийн малчин У.Ням, Б.Пүрэвсүрэн, Жаргалант багийн малчин Т.Чулуун, Д.Хүдэрбаатар, Жавхлант багийн малчин А.Баатарчулуун, Г.Чинбат, Д.Төмөр-очир, Дэлгэр багийн малчин Э.Очирдорж, Л. Базарханд, Л.Амгаланбаатар нар тус тус тодров. Мянгат малчнаар Баян багийн малчин М.Одхүү, М.Баянбат, Тэгш багийн малчин О.Даарийжав нар тус тус тодров.

Хүнс, худалдаа, үйлчилгээний талаар:

2021.02.22ны байдлаар “Гүн Хүсэл”, “Хишиг”, “Өгөөж”, “Дэлгэрэх”, “Эрдэнэ-Оргих”, “Баян” гэсэн 6 аж ахуйн нэгжүүд дараах хүнсний бүтээгдэхүүний нөөцтэй байна.

- | | |
|------------------------------|--------------------|
| • Гурил – 2тн 775кг, | Төмс-190кг |
| • Гурилан бүтээгдэхүүн-340кг | Хүнсний ногоо-50кг |
| • Будаа-1тн 285кг | Элсэн чихэр-335кг |
| • Хуурай/Шингэн сүү-495ш | Давс-260кг |
| • Өндөг-0ш | Савласан ус-0ш |
| • Ургамлын тос-281ш | |

Уулбаян сумын шатахуун түгээх станц нь А-92 – 8тн 700л, А-80 – 22тн 480л, ДТ-19тн 200л нөөцтэй байна.

Уулбаян сумын хүнс, барааны нийт 6 дэлгүүрийн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнүүд дараах үнэтэй байна. Үүнд:

- | | |
|-------------------------|-------------------|
| ○ Гурил- 31500-33500төг | Төмс-1300-1500төг |
|-------------------------|-------------------|

- | | |
|-------------------------------------|----------------------------|
| ○ Гурилан бүтээгдэхүүн-3000-4500төг | Хүнсний ногоо-2500-3000төг |
| ○ Будаа-2700төг | Элсэн чихэр-2500-2800төг |
| ○ Хуурай сүү-3400-3500төг | Давс-1000-1100төг |
| ○ Өндөг-800төг | Савласан ус-600-3500 |
| ○ Ургамлын тос-4300-6200төг | |

Сумаас аймаг нийслэл руу мах тээвэрлэсэн байдлын талаар:

2021.0.2.03-2021.02.17-ний хооронд Улаанбаатар хот руу 2тн 250кг, Хэнтий аймаг руу 1тн 680кг, нийт 3тн 930кг мах тээвэрлэсэн.

Аймаг, нийслэл руу мах тээвэрлэх хүмүүст тээвэрлэлтийн эрх болох QR кодыг энэ сард нийт 4 хүнд олгосон.

Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн хадгалах горим, хадгалахад анхаарах температур чийгшил хугацааны талаарх мэдээллийг худалдаа, үйлчилгээ эрхлэгчид 2021.2.11нд өгсөн болно.

2021 оны 02 дүгээр сарын 11-ны өдөр Сумын хэсгийн цагдаа Э.Анхбаяр болон олон нийтийн цагдаа Э.Хатантөмөр нартай хүнсний худалдаа, үйл ажиллагаа явуулж буй 5 аж ахуйн нэгжүүдэд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хугацаа дууссан эсэхэд хяналт, шалгалт хийхэд дараах зөрчлүүд илэрсэн:

2019-2020 онд хугацаа дууссан 7 нэр төрлийн 165 ширхэг, 66400 төгрөгийн үнэ бүхий бүтээгдэхүүнийг хураан авч устгалын комисст шилжүүлж устгалд оруулсан. Үүнд:

- ✓ “Гүн хүсэл ХХК”-аас 2 ширхэг “Alpen gold dark” үйлдвэрлэсэн хугацаа нь 2019.10.28 өдөр, дуусах хугацаа 2020.10.20 өдөр.
- ✓ “Орлой баян зээрд” ХХК”-аас 2 ширхэг “Фрутта ундаа” үйлдвэрлэсэн хугацаа 2019.12.08 өдөр, дуусах хугацаа 2020.12.08 өдөр.
- ✓ “Дэлгэр ХХК”-аас 1 ширхэг “Слодыч печень” үйлдвэрлэсэн хугацаа 2019.12.13 өдөр, дуусах хугацаа 2020.12.13 өдөр.
- ✓ “Барааны дэлгүүр”-ээс 22 ширхэг “Jurry cherry” сироп үйлдвэрлэсэн хугацаа 2018.4.4 өдөр, дуусах хугацаа 2020.4.4 өдөр.
- ✓ 2 ширхэг “Хаан чипс” үйлдвэрлэсэн хугацаа 2020.2.17 өдөр, дуусах хугацаа 2020.7.17 өдөр.
- ✓ 30 ширхэг “Чавга” үйлдвэрлэсэн хугацаа 2019.4.6 өдөр, дуусах хугацаа 2020.4.6 өдөр.
- ✓ 106 ширхэг “XIN HUI Чавга” үйлдвэрлэсэн хугацаа 2018.08.30 өдөр, дуусах хугацаа 2020.08.30 өдөр

Аймгийн Засаг даргын 2021.02.01ны өдрийн А/83 дугаар захирамжаар “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг 2021.2.15-ны өдрийг дуустал сунгасантай холбогдуулан аймгийн хэмжээнд 18 градусаас дээш бүхий архи согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг 2021.02.15-ний өдрийг дуустал хориглосугай” гэсэн захирамжийг архи худалдан борлуулдаг тусгай зөвшөөрөлтэй 4 дэлгүүрт хүргүүлсэн.

Сум хөгжүүлэх сангийн тухайд, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021.01.27-ны өдрийн 1/19 дугаар үүрэг чиглэлийн дагуу Сум хөгжүүлэх сангийн зээлийн

мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн системд шилжсэнтэй холбогдуулан аж ахуйн нэгж, иргэдэд программын холболтын талаарх мэдээллийг /мэдэгдэл/ хүргэж гарын үсэг зуруулж авсан.

Уулбаян суманд 6 нэр төрлийн ахуй үйлчилгээ эрхлэгч байна. Ахуй үйлчилгээ эрхлэгчдээс мэдээллийн хавралт өгөгдлийн дагуу судалгааг авсан.

Нэр төрлөөр нь ангилан үзвэл:

- Авто машин засвар үйлчилгээ эрхлэгч- 4
- Гутал засвар үйлчилгээ эрхлэгч – 1
- Гэрэл зурагчин фото үйлчилгээ эрхлэгч- 1
- Хувцас захиалга үйлчилгээ эрхлэгч- 2
- Гэр ахуйн модон эдлэл захиалга эрхлэгч-1
- Үсчин-1

Ахуй үйлчилгээ эрхлэгчид нь 2008 - 2020 оны хооронд үйл ажиллагаа явуулж эрхэлсэн ба нас хүйсээр нь ангилан үзвэл эрэгтэй-6, эмэгтэй-4 байна. Үйл ажиллагаа явуулдаг өөрийн өмчлөлийн байртай 6 эрхлэгч байна.

Мал эмнэлэг:

Аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2021 онд мал аж ахуйн татвар авах болсонтой холбогдуулан танай суманд мал эрүүлжүүлэх ажлын чиглэлээр ямар ажил хийж хэрэгжүүлэх боломжтой талаар судалж саналааа ирүүлэх үүрэг чиглэл, даалгаврын дагуу сумын Засаг дарга Д.Амартайвантай уулзаж малын татварын орлогоос ямар ажил хийж хэрэгжүүлэх талаар зөвшилцөж эхний ээлжинд мал угааллагын ванн барих, сэргээн засварлах ажилд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэхээр болж уг саналаа аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлсэн.

2021 оны 01 сарын 29 нд аймгийн Мал эмнэлгийн газрын халдвартын их эмч С.Мөнхэрдэнэ-д сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн, хувийн хэвшлийн мал эмнэлгийн малын эмч нарын судалгааг гаргаж хүргүүлсэн.

Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын малын эмч Г.Мөнхзулд хувийн мал эмнэлгүүдийн мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлэх малын тоо, байршлын зураглал, мал угаалгын ванны судалгаа зэргийг гаргаж хүргүүлсэн.

Аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2021 оны 02 сарын 18 ны өдрийн Чиглэл хүргүүлэх тухай албан тоотыг сумын Засаг даргад танилцуулан авах арга хэмжээг төлөвлөн албан тоотын хариуг хугацаанд нь аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхээр болоод байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:

Алдарт эхийн одонгийн баталгаажуулалт хийсэн. Хугацаа нь дууссан 18 эхийн мэдээллийг шинэчлэн бүртгэсэн. 2021.02.10 өдрөөр 65 хүрч байгаа 9 иргэнийг

насны хишигт бүртгэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй 11 хүүхдийг түлээ нүүрсний хөнгөлөлтөнд хамруулсан. Тэжээгчээ алдсаны тэтгэмжинд-1 иргэн, тэтгэвэр тэтгэмжинд-1 иргэн, жирэмсэн эхийн тэтгэмж-2, цалинтай эх-5, хүүхдийн мөнгөнд-9 хүүхэд бүртгэсэн. www.ehalamj.mn -д шилжиж байгаа 47 иргэнийг данс дугаар болон холбогдох утасны дугаарыг программд шивсэн. Мөн төрийн харъяалалтай 235 ахмад настныг дансны дугаар, холбогдох утасны дугаарыг бүртгэсэн. Гэрчилгээ сольсон 1 хүүхэд, Цалинтай эх буюу 2226 дээр хураас зогсоосон нэг иргэнийг сэргээсэн.

Нийгмийн даатгал:

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 35258.8 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ. Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд - 26941.5 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 5398.5 мян төг
- ЭМДаатгалын шимтгэлд- 2918.8 мян төг орлоо.

Хэлтсээс 150000.0 мян төгрөгийн санхүүжилт авч 446 тэтгэвэр авагчдад 316243.1 мян төгрөгийн тэтгэвэрийг олголоо.

СДДаатгалд 72 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 5379.5 мян төгрөгийн шимтгэл, Эрүүл мэндийн даатгалд 60 даатгуулагчийг даатгаж 2918.8 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Шинээр өндөр насны тэтгэвэр -13, тахир дутуугийн тэтгэвэр-, тэжээгчээ алдсаны тэтгэвэр -1 нийт 14 тэтгэвэр, 1 тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн, 3 даатгуулагчдад ажилгүйдлын тэтгэмж тогтоогоод байна.

Оршуулгын тэтгэмж 3 тэтгэвэр авагчдад 3000.0 мян төгрөг жирэмсэн амаржсаны тэтгэмжинд 1даатгуулагчдад 1072,8 мян төгрөгийн тэтгэмжийг тус тус олголоо.

2020 оны харилцах, тооцооны хуудас тайлан, зогсоогдсон тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох өргөдөл- 14, тэтгэвэр авах зөвшөөрөл-5, Банк солих-2, тэтгэмж-5, ажилгүйдлын тэтгэмж-3, малчнаар ажилласан жил тотоолгох-4 нийт 33 өргөдлийг хүлээн авч бүрэн барагдуулж, 202 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

Эрүүл мэнд:

Урьдчилан сэргийлэх үзлэг-144, амбулаторийн үзлэг –170, гэрийн дудлага-18, алсын дуудлага-16, артерийн даралт – 71, чихрийн шижингийн үзлэг-71, хөхний үзлэгт-52, 0-2 насны урьдчилан сэргийлэх тарилгад- 27, саагийн нэмэлт дархлаажуулалтанд-125 нийт 319 иргэд тус тус хамрагдсан байна.

Ерөнхий боловсролын сургууль :

- 1,2,5,9-р ангийн нийт 135 суралцагчдад давтлагыг бага ангийн 6 багш, мэргэжлийн 7 багш нар өгч байна.
- Сургуулийн ХХБ-аас 5 хүүхдийн гэрийн эргэлт хийв.
- “Хүүхэд хамгаалал”, “Ахуйн осол”, “Ковид 19” сэдвээр багш нар нийт 20 шторк бэлтгэн олон нийтийн сүлжээнд байршуулав.
- Бага ангийн багш нар ажлын өдөр бүр 1 бодлого бодож, 2-р сард нийт 190 бодлого бодсон.
- Багшийн туслахад 9-р ангийн 16 хүүхэд нэвтэрч, хичээл хийж, сорил даалгаврыг гүйцэтгэж байна.
- 23 багш сурах бичигт анализ хийсэн.
- Сумын ЭМТ-ээр 1 удаа ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн.
- Эцэг эхийн gmail хаягтай болгож, мэдээллийн системд нэвтрэх эрхтэй болгосон.
- 1-р сургуулийн 3 багш Канадын “Нар хүүхдээс манддаг” төслийн хүрээнд сургалт зохион байгуулж, 13 багш хамрагдсан.
- Аймгийн нийтийн сангаас зохион байгуулсан “Амар мэндийн баяр” гар зургийн уралдаанд 6 хүүхэд оролцсоноос 36 ангийн сурагч О.Сарнай 2-р байр эзэлсэн. “Монгол банхараа хэн сайн зурах вэ?” уралдаанд 5 хүүхэд оролцсон.
- “Хашаандаа сайхан амьдрая” аянд 8 хүүхэд оролцсон.

Хүүхдийн цэцэрлэг:

1. Манай байгууллагын нийт ажилчдын 54.5% нь 0-12 хүртлэх насны хүүхэдтэй ба эдгээр ажилчдыг гэрээр ажилуулж байна. Үлдсэн багш ажилчдын 18.1%-ийг ээлжийн ажилтай хүмүүс /галч жижүүр/ эзэлдэг ба 27.2% нь богиносгосон цагаар ажиллаж байна.
2. Богиносго цагаар ажиллаж байгаа багш ажилчдын амны хаалт, халууныг өдөр бүр хэмжиж тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Мөн дархлааг нь дэмжиж халуун аарц, чацаргана өгч байна.
3. Багш нар гэрээр бүх бүлгийн “Теле хичээл”-ийг үзэж тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Мөн теле хичээлийн хамрагдалт 80,7%-тай байна.
4. Манай байгууллага 2020 оны ажлаараа 13-н сумаас 2-р байранд шалгарч өмнөх оны амжилтаа ахиуллаа.
5. БТДИ-ээс цахимаар зохион байгуулсан сонголтот сургалтуудад эрхлэгч, багш, туслах багш нар хамрагдлаа
6. Цахим хуудсанд багш ажилчид хуваарийн дагуу “Хүүхэд хамгаалал аюулгүй байдал”-5, “Ковид-19”-7, эрүүл ахуйн-8, зэрэг зөвлөмж зөвлөгөө уриалгыг байршуулаад байна.
7. Сумын Засаг даргын А/17 дугаар захирамжийн дагуу “Цагаар сар”-ын шинийн нэгнээс шинийн 3-ны өдрүүдэд 4 замын уулзварт эмэгтэй ажилчид, хөдөлгөөнт постын эргүүлд эрэгтэй ажилчид ажиллаа.
8. Хорио цээрийн үед сумын ЭМТ-тэй хамтран 2 удаагийн ариутгал халдваргүйтгэлийг байгууллагын гадна, дотор орчин хийлээ. Мөн байгууллагын халдвар хамгааллын баг байгууллагын дотор ариутгал халдваргүйтгэлийг 2 удаа хийсэн.

Соёлын төв:

Нийтийн номын сан цахим хуудсанд тууж-2, өгүүллэг-31, танин мэдэхүйн нийтлэл-9 түгээж нийт 1520 хүний хандалт авсан байна. Сар шинийн баярыг тохиолдуулан Монгол ардын дууны уралдааныг иргэдийн дунд зохион байгууллаа. ЕБС дээр зохион байгуулагдсан Канад төслийн сургалтанд хамрагдлаа. Сар шинийн үеийн хорио цээрийн дэглэмийн тогтоох ажилд байгууллагын 2 ажилтан постонд гарлаа.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүргүүлсэн. Мэдүүлэг гаргагч нарт гарын авлага өгч, арга зүйн зөвлөгөөг утсаар болон цахимаар өгсөн.

Улсын Онцгой Комиссын 01 тоот албан даалгаврын биелэлтийг энэ сард 4 удаа шуурхай штабт хүргүүлсэн.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор иргэд цахим орчинд хонжворт сугалаа, мөрий тавих, азтан шалгаруулах лайвт оролцож гэмт хэргийн хохирогч болох, мөн гэмт хэргийн өсөлт нэмэгдэж байгаатай холбоотойгоор холбогдох хуульд заасан зөвшөөрөл, хуулийн хариуцлага зэргийг цахим хаягаар мэдээлэл хүргэсэн болно.

Тусгай дугаарын /98514040/ утасыг ажиллуулж иргэдийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж байна.

2020 оны 2 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг-1, Хүнийг алах – 1 гэмт хэрэг нийт 2, танхайрах зөрчил - 2 тус тус үйлдэгдсэн байна.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ДАШБАЛЖИННЯМ